

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

№01

Улаанбаатар хот

Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг **2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт 11:00 цагт** эхлэв.

Крипто Үндэстэн ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, талархал илэрхийллээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж өгнө үү хэмээн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягыг урив.

Хурлыг нээж: ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд мэнд дэвшүүлэв. Хурлын ирц амжилттай бүрдсэн байна. Өнөөдөр хувьцаа эзэмшигчдийн хуралдаа амжилттай оролцохыг хүсэв.

Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулахыг урив.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2024 оны 4 сарын 30-ны өдрийн 1 тоот тогтоолыг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нийт гаргасан 113,212 ширхэг энгийн хувьцаа байна. Үүнээс саналын эрхтэй 102,389 ширхэг энгийн хувьцаанаас **61,296** ширхэг буюу **59.87** хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Өнөөдрийн хурлын ирц хуулийн шаардлага хангаж байгаа тул Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаа эхлүүлье. Хувьцаа эзэмшигчдэд хурлын дэгийг танилцуулав. Өнөөдөр дараах асуудлуудыг хэлэлцүүлэх болно. Үүнд:

1. 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай
7. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх тухай
8. ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
9. Бусад асуудал;

Хэлэлцэх асуудал -1

2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн түүхэн замналын тухайд дурдвал 2022 онд Булган Ундарга ХК рүүсгэн байгуулагдаж байсан бол 2017 онд Крипто Үндэстэн ХХК үүсгэн байгуулагдаж Крипто Үндэстэн Чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж байсан. 2020 онд Булган Ундарга ХК-тай Крипто Үндэстэн ХХК-ийг нэгтгэсэн. 2022 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр BUN тикерээ CNF болгон сольж арилжаалагдаж эхэлсэн. Компанийн одоогийн зах зээл дээр гаргасан хувьцааны тоо 113,212 ширхэг байна.

2024 оныг тоймчлон авч үзвэл:

- 2024 онд инфляц буурч, томоохон төв банкууд анх удаа хүүгийн түвшинг буурууллаа.
- Бүс нутгийн геополитикийн зөрчил үлдсэн ч дэлхийн эдийн засаг тогтвортой байна.

- 2024–2025 онд дэлхийн бодит ДНБ 3.2%-аар өсөх төлөвтэй (2023 онд 3.3% байсан).
- Криптовалютын зах зээлийн үнэлгээ 2024 онд 3.9 их наяд ам.доллар болж, жилийн өмнөхөөс 127%-аар өссөн.
- АНУ-д BTC, ETH спот ETF-үүд нээгдэж, институцийн хөрөнгө оруулалт нэмэгдэв.
- BTC ETF хөрөнгө \$30.7 тэрбум, ETH ETF хамгийн өндөр сарын урсгал \$1.1 тэрбумд хүрэв.
- Bitcoin 12-р сард \$100,000 давж, ETF, АНУ-ын сонгууль, халвингийн нөлөөгөөр өсөв.
- Ethereum-ийн Dencun шинэчлэлт Layer 2 төлбөрийг 99%-аар бууруулж, хэрэглээг нэмэгдүүлэв.
- AI ба Web3 нэгдэл нэмэгдэж, Солана тав дахь том крипто болов.
- Prediction market тэлж, Polymarket арилжаа \$2.6 тэрбумд хүрэв.
- Токенжуулсан хөрөнгө, RWA зах зээл \$13.6 тэрбумд хүрч, ЗГ бондод суурилсан токен 239%-аар өсөв.
- Крипто хөрөнгө оруулалт \$12.3 тэрбумд, блокчейн үйлчилгээ \$4.5 тэрбумд хүрэв.

Санхүү байдлын тайлан

(мянган төгрөг)	2023	2024	YoY
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	995	61,402	6,071.08%
Дансны авлага	798,767	54,209	(93.21)%
Бусад санхүүгийн хөрөнгө	216,473	201,020	(7.14)%
Урьдчилж төлсөн зардал	278,206	292,468	5.13%
Бусад эргэлтийн хөрөнгө	4,485,059	7,877,705	75.64%
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	1,496	1,496	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		500,000	

Нийт хөрөнгө	5,780,996	8,988,300	55.48%
Дансны болон бусад өглөг	609,036	620,997	1.96%
Татварын өглөг	3,448	3,450	0.08%
Богино хугацаат өр төлбөр	612,484	624,447	1.95%
Хойшлогдсон татварын өр төлбөр	157,678	427,898	171.37%
Урт хугацаат зээл		484,200	
Урт хугацаат өр төлбөр	157,678	912,098	478.46%
Өр төлбөрийн нийт дүн	770,162	1,536,545	99.51%
Өмч-хувьцаат	11,321	11,321	
Нэмж төлөгдсөн капитал	8,421	8,421	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,419,104	3,851,076	171.37%
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,464,259	3,464,259	
Хуримтлагдсан ашиг алдагдал	107,728	116,677	8.31%
Эздийн өмчийн дүн	5,010,834	7,451,755	48.71%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	5,780,996	8,988,300	55.48%

Орлогын дэлгэрэнгүй тайлан

(мянган төгрөг)	2023	2024	YoY
Бусад орлого	28,005	62,622	123.61%
Хүүний орлого	19,783	-	-
Нийт орлого	47,787	62,622	31.04%
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	143,486	91,475	(36.25%)

Санхүүгийн зардал	-	66,225	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	2,574	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-	-
Бусад олз (гарз)	7,464	101,452	1,259.3%
Нийт зардал	136,023	53,674	(60.54%)
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(88,235)	8,948	110.14%
Орлогын татварын зардал	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(88,235)	8,948	110.14%
Бусад дэлгэрэнгүй орлого	1,419,104	2,431,972	71.37%
Орлогын нийт дүн	1,330,869	2,440,920	83.41%
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	12	22	83.33%

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Нэр	2024	Хувь	2025	Хувь
1	Ард Даатгал ХК	25,000	22.08%	25,979	22.95%
2	Ард Бит ХХК	11,028	9.74%	10,823	9.56%
3	Ардын Тэтгэврийн Данс ХХК	9,352	8.26%	9,884	8.73%
4	Эйч Ви Эл Эл ХХК	9,631	8.51%	9,631	8.51%
5	Хөвсгөл ХК	5,854	5.17%	5,856	5.17%
6	С.Оргодол	5,025	4.44%	5,025	4.44%

7	Үндэсний Хувьчлалын Сан ХОС	3,258	2.88%	3,258	2.88%
8	Хаан Банк Кастодиан	2,610	2.31%	2,610	2.31%
9	Ц.Энх-Амгалан	2,076	1.83%	2,078	1.84%
10	Э.Хасар	2,021	1.79%	2,021	1.79%
11	А.Тулга	2,020	1.78%	2,020	1.78%
12	Монгол Дифай ХХК	1,987	1.76%	1,987	1.76%
13	Ч.Ганхуяг	1,869	1.65%	1,875	1.66%
14	Бусад 2,254 хувьцаа эзэмшигч	31,481	27.81%	30,165	26.64%

Хувьцаа эзэмшигчдийн тоо



Арилжааны мэдээ

Огноо	Нээлт	Дээд	Хаалт	Нийт арилжааны дүн	Жигнэсэн дундаж ханш	Нийт арилжсан ширхэг
-------	-------	------	-------	--------------------	----------------------	----------------------

2021	₮874.92	₮ 224,300	₮ 164,900	₮ 2.5 тэрбум	₮61,507.83	41,974
2022	₮164,800	₮ 164,800	₮90,720	₮ 420.4 сая	₮ 104,263.8	4,033
2023	₮90,000	₮90,000	₮52,000	₮ 534.6 сая	₮ 65,340.50	8,182
2024	₮69,000	₮77,800	₮77,450	₮ 793.0 сая	₮ 48,691.07	16,286

Хөрөнгө оруулалтын багц

Тикер	Хэмжээ	Багцын эзлэх %	2024-12-31 үнэлгээ (₮)
BTC	9.18	37.24%	2,933,480,211
ARDX	72,146,245.58	29.31%	2,308,679,859
TON	100,000	23.84%	1,877,717,250
BS9	193,407.80	2.95%	232,089,360
stETH	33.54	4.85%	382,327,620
ETH	8.1	1.17%	92,357,334
USDT	9,761.35	0.42%	33,386,257
ARDM	1,333,333,333	0.22%	17,600,000
НИЙТ			7,877,637,892

Хөрөнгө оруулалт

Toncoin (TON)

- Toncoin (TON) нь The Open Network (TON)-ийн үндсэн криптовалюта юм.
- Технологийг 2020 оноос хойш бие даасан хөгжүүлэгчид боловсруулж, TON сангийн дэмжлэгтэйгээр The Open Network нэртэй блокчейн болж, Toncoin нь үндсэн криптовалюта болсон. Toncoin нь proof-of-stake (PoS) загвар ашигладаг.
- TON сан 2028 он гэхэд 500 сая хэрэглэгчийг дижитал өмч, өгөгдөл, хөрөнгөө эзэмших боломжтой болгох зорилготой.

BlueSky 9 (BS9)

- Хөх Тэнгэр төсөл нь хотын төвийн "А" зэрэглэлийн бүсэд орших үл хөдлөх хөрөнгийг дэлхийн хаанаас ч хэсэгчилж эзэмшин, түрээсийн орлоготой болж, долларын өгөөж хүртэх боломжийг хөрөнгө оруулагчид олгох төсөл юм.
- Блю Скай Тауэр нь Улаанбаатар хотын төвийн "А" бүст байрлалтай 25 давхар, 105 метр өндөр таван одтой зочид буудал, 12 айлын орон сууц, албан оффис хосолсон загвар дизайн, барилгын чанар зэрэг үзүүлэлтүүдээрээ тэргүүлэхүйц, архитектурын цогц шийдэл бүхий байгууламж юм.

2025 оны зах зээлийн төлөв

- **Bitcoin нөөц ба үнэ тогтворжих:** Биткойныг дэлхий даяар нөөцдөө оруулах нь үнийг тогтворжуулахад туслах бөгөөд үнийн өсөлтийг өдөөж магадгүй.
- **AI ба Web3-ийн нэгдэл:** Криптод AI-ийн хөгжүүлэлт үргэлжилж, төвлөрсөн бус баталгаажуулалт ба олон агентын системүүдийн судалгаа үргэлжлэх болно.
- **Prediction зах зээлийн өсөлт:** Улс төрийн бус үйл явдлууд тааврын зах зээлд эрчтэй өсч, сонирхол нэмэгдэж байна.
- **Стэйблкойны хууль эрх зүй ба өргөжилт:** Тодорхой хууль эрх зүйн дэмжлэгтэй шинэ стэйблкойнууд гарч магадгүй.
- **Крипто эзэмшигчдийн тоо өсөх:** Дэлхий даяар крипто эзэмшигчдийн тоо 2025 онд 750-900 саяд хүрэх төлөвтэй.

- **RWA-ийн өргөжилт:** Санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр RWA-ийн өсөлт нь жижиг бизнесүүдийн санхүүжилтийг шинэчлэх боломжтой.
- **Институцийн хөрөнгө оруулалт өсөх:** Solana (SOL) болон XRP (XRP) ETF-үүдийн гарснаар институцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх магадлалтай.
- **Ethereum-ийн Pectra шинэчлэлт:** Ethereum-ийн үр ашгийг сайжруулах зорилгоор Pectra шинэчлэлт хийх болно.

2025 оны төлөвлөгөө

1. Бонд гаргах (3 – 5 тэрбум)
2. Хувьцаа токенжуулалт CNFT
3. УБҮЦ бирж лист хийх

Хэлэлцэх асуудал-2

2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах.

Танилцуулсан: Хүлэгт Хүннү Аудит ХХК ахлах аудитор Х.Амартүвшин

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хүлэгт Хүннү Аудит ХХК-ийн ахлах аудитор Х.Амартүвшин байна. Кripto Үндэстэн ХК-ийн тайланд Хүлэгт Хүннү Аудит 3 дах жилдээ аудит хийж байна. Энэ удаагийн аудит 2 сарын хугацаанд санхүү байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эздийн өмчийн тайлан болон түүнтэй холбоотой нэмэлт тайлангууд болон холбогдох баримт бичгийг үндэслэн санхүүгийн тайланд иж бүрэн аудит хийсэн байна. Энэ хугацаанд санхүүгийн тайланд шаардлагатай олон улсын стандартыг хэрэгжүүлж Кripto Үндэстэн ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцсэн зөрчилгүй дүгнэлтийг гаргасан байна.

Хэлэлцэх асуудал-3

2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.

Хэлэлцэх асуудал-4

2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ нь 2024 онд нийт 3 удаа хуралдсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийт 12 тогтоол гаргаснаас зөвлөлийн ээлжит хурлаар нийт 5 тогтоол гаргасан, Эчнээ саналын хуудсаар 7 тогтоол гаргасан байна. ТУЗ нь компанийн 2023 оны Үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг баталж ажилласан байна.

Хэлэлцэх асуудал-5

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 сарын 19-ний өдрийн №25/01 тоот тогтоол

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, “Крипто Үндэстэн” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5-ыг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг цаашид хэвийн тогтвортой явуулахтай холбоотойгоор 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй болохыг мэдэгдсүгэй.
2. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дах хэсэгт зааснаар ногдол ашиг хуваарилахгүй байх тухай асуудлыг нийтэд мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

Хэлэлцэх асуудал-6

ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай.

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв

№	Зардлын төрөл	Давтамж (улирлаар)	Нэгж зардал	Сар	Зардал
1	Бичиг хэрэг, хангамж	4	50,000.00	12	200,000.00
2	Бусад	4	200,000.00	12	800,000.00
Нийт зардал					1,000,000.00

Хэлэлцэх асуудал-7

ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дараах албан тушаалтнуудыг нэр дэвшүүлснийг тус бүрд нь танилцуулав. ТУЗ-ийн ердийн гишүүнд Ч.Ганхуяг, Д.Чадраабал, Б.Золбоо, Ч.Ганзориг, Г.Мягмаржав, О.Мөнх-Оргил нар ТУЗ-ийн хараат бус гишүүнд А.Тулга, Э.Хасар, Ц.Энх-Амгалан нарыг танилцуулав.

Асуулт хариулт

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

Хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхэлснийг зарлаж асуултыг заалнаас болон Ард Апп-аар дамжуулж авах талаар мэдээлэл өгөв. Заалнаас асуулт асуугаагүй тул асуулт, харилт дуусав.

Санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Кripto Үндэстэн ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 2,3,4,5 тоот тогтоолын санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Нийт хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 11:00 цагаас 11:10 цаг хүртэл ирцийг авсан. Хуралдаанаар **61,296** ширхэг буюу **59.87** хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

1. Санал хураалтын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 13

Хувьцааны тоо: 59,770 ширхэг.

Нийт саналын эрх бүхий хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 58.3%

2. Хурлаар санал хураалтад оролцож өгсөн санал /Ард Апп/:

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 37

Хувьцааны тоо: 1,526 ширхэг.

Нийт хувьцаанд эзлэх хувь хэмжээ: 1.49%

3. Хүчингүй санал: 0

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 0

Хувьцааны тоо: 0 ширхэг.

Крипто Үндэстэн ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд "Компанийн тухай" хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу томилогдсон тооллогын комисс гүйцэтгэв.

Тооллогын комисс бүрэлдэхүүнд даргаар Ө.Бямбагэрэл, гишүүдээр: Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн нар ажилласан болно.

Гүйцэтгэх захирал хурлыг хаан үг хэлэв.

Хурал 13 цаг 00 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Ч.ГАНХУЯГ

Б.УРАНЦЭЦЭГ